

Т.Сараннэмэх

*Нийслэлийн Боловсролын газрын багшийн хөгжил
насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн*

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа болон хичээлийг заах арга зүйн зөвлөмж

Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангиас эхлэн ирээдүйн ажил мэргэжлээ өөрийн сонирхол, ур чадвар, эрхэмлэдэг үнэт зүйл болон хувь хүний шинж чанарт тохируулан сонгох явдал нь хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээтэй уялдах, бүтээмжтэй ажиллах сэтгэл ханамжтай байх зэрэг олон үйл ажиллагаатай холбоотой.

Зарим орны судлаачдын (жишээ нь Vu Tuan Anh, 2014) цохон тэмдэглэснээр дээд боловсролтой иргэд ажилгүй байгаагийн үндсэн шалтгаан нь тэдний өөрсдийн эсвэл эцэг эхийн хийсэн ажил мэргэжлийн алдаатай сонголт байдаг.

Судлаачдын (Killeen, White & Watts, 1992; Rosen, 1995; Watt, 1996; Bysse, Hughes & Bowes, 2002) үзэж байгаагаар ЕБС-ийн ажил мэргэжлийн чиг баримжаа нь тухайн үндэстний боловсролын болоод хөдөлмөрийн зах зээлд маш эерэг нөлөөтэй. Түүнчлэн ЕБС-ийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг үр дүнтэй олгосноор тэдний сургалтын болон мэргэжлийн сонголтын чанарыг сайжруулах ба ингэснээр сурах үйл ажиллагаандаа хариуцлагатай хандах, сурлагын амжилт сайжрах үндэс болдог (Lapan, Gysbers & Sun, 1997).

ЕБС-ийн сурагчдыг өөрийн хүсэл сонирхол дээрээ тулгуурлан ажил мэргэжлээ зөв сонгох боломжийг хөгжүүлэх зорилгоор 2016 оноос 8-9-р ангийн, 2018 оноос ахлах ангийн сурагчдад АМЧБО чиглэлээр үйл ажиллагаа явагдаж, улмаар албан хичээл эхлэн орж байгаа билээ. Энэхүү үйл ажиллагааг тогтмол хэвшил болгосноор эдийн засгийн даяаршлын эринд нийгэмд тулгарч буй асуудлыг даван туулах мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, сургалт хөдөлмөрийн хоорондын зохистой уялдааг хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зөрүүг багасгах, насан туршдаа суралцах зорилтыг бий болгоно.

Оксфордын англи хэлний толь бичигт “Career” гэдгийг хувь хүний амьдралын эсвэл тодорхой үеийн үйл ажиллагааны хөгжил дэвшил гэж тодорхойлсон байдаг бөгөөд манай улсад “ажил мэргэжил” гэж орчуулж хэрэглэж байна.

АМЧБО үйл ажиллагааг явуулахдаа дараах хууль, эрх зүйн орчинтой танилцах нь чухал. Үүнд:


- Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.3 заалт: “бүрэн дунд боловсролын агуулга нь мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэнэ”
- Улсын их хурлын 2015 оны 12-р тогтоолын “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) 3.5 хэсэг: бүрэн дунд боловсролыг “сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий, ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ”
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр: 3.17 дугаар хэсэгт суралцагчдад ажил мэргэжил болон боловсрол, сургалтын чиглэлээ сонгоход туслах ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээг бий болгох
- 2016 оны 6 сарын 24-ний өдөр ХНХЯ болон БСШУСЯ-ны сайдын хамтарсан тушаал: “Ажил мэргэжлийг чиг баримжааг хөгжүүлэх” чиглэлээр “иргэн бүрийн насан туршдаа сурч боловсрох, ажил хөдөлмөрийн сонголтгоо хийх, ажил мэргэжлийн замаа удирдан хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь туслах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, арга зүйн удирдлагын нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх”
- БСШУСЯ –ын 2018 оны 8-р сарын 07 4/9353 тушаал хэрэгжүүлэх тухай: *Ахлах ангийн сургууль зохицуулах цагт АМЧБО үйл ажиллагаа болон сургуулийн өөрийн боловсруулсан хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлнэ.*

Хэрэгжилтийн байдлаас харахад сургуулийн болон ангийн түвшний хөтөлбөрийг боловсруулан ашиглаж байна. Гэхдээ уламжлал болсон /”Мэргэжил бүхэн сайхан”, зочин урих, ажлын байр, МСҮТ дээр очих г.м/ хэдэн ажлуудыг зохион байгуулж, их дээд сургуулиудын сурталчилгааны ажлуудад оролцохоос өөр шинэлэг, хүүхдийн сонирхолд нийцсэн ажлуудыг зохион байгуулах тал дээр дутмаг байна.

2018-2019 оны хичээлийн жилд ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд сургуулийн мэдлийн 70 цагийн 35 цагийг АМЧБО хичээл оруулахаар тусгасан. Сургууль бүр сургуулийн болдлого, үйл ажиллагаатай уялдуулсан сургуулийн болон ангийн түвшний хөтөлбөрийг боловсруулж, АМЧБО үйл ажиллагааг явуулах нь үр дүнтэй.

АМЧБО хичээл нь сурагчдын хандлага, сурах арга барилд өөрчлөлт ахиц гаргаж, ажил мэргэжлээ зөв сонгон бие даан хөгжих боломжоор хангах зорилготой.

Ерөнхий боловсролын сургууль дээр АМЧБО үйл ажиллагааг явуулж болох нөөцийг дараах зураг /1/ дээр харуулав.



Зураг 1.

Сургуулийн удирдлагууд нь АМЧБО үйл ажиллагааг бодлоготой, төлөвлөсөн хөтөлбөрөөр явуулж, түүний хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийнэ. Ялангуяа албан хичээл орсонтой холбоотойгоор сургалтын менежер сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөгөө өгч байхгүй бол нэгэнт сонголтоо хийчихсэн юм чинь гээд ахлах ангийн сурагчид сонирхохгүй, идэвхгүй болох хандлага ажиглагдаж байна. Багш, сурагч, эцэг эхчүүд АМЧБО үйл ажиллагаанд хамтран ажиллах байгууллагуудын жагсаалтыг гарган боломж, давуу, сул талын шинжилгээ хийж, тодорхой санал, төсөл боловсруулж болно. Ингэснээр сургууль дээр зохиогдож буй ажил нь мэдээлэл сайтай, албан хүчээр хамруулахгүй, нэг ажлыг нөгөөгөөр үгүйсгэхгүй, үр дүнг тооцоож болох олон талын ач холбогдолтой.

Эцэг эхчүүд болон сурагчдаас авсан судалгаанаас харахад АМЧБО мэдээлэл чухал байгааг тэмдэглэсэн байдаг. Иймд сургуулийн мэдээллийн самбар, вэйб сайт зэрэгт АМЧБО чиглэлээр байнгын тогтмол мэдээлэлтэй байх нь зүйтэй. Үүнд:

- АМЧБО үйл ажиллагааны сургуулийн хөтөлбөр
- Тодорхой ажил мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээлэл
- Тохирсон ажлаа сонгоход өгөх мэргэжлийн зөвлөгөө
- Мэргэжлээ хэрхэн сонгох талаар зөвлөгөө
- “Ажил мэргэжил болон суралцах чиглэлийн төлөвлөгөө” боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний талаарх мэдээллийг авч болох байгууллагуудын жагсаалт:

- Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
- Ажил, мэргэжлийн мэдээллийн төв
- Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар
- Хөдөлмөр, нийгэм хамгааллын судалгааны институт
- Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар



- Дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- Ажил мэргэжлүүдийн үндэсний зөвлөхүүдийн холбоо
- АМЧБО төв
- Хөдөлмөрийн биржүүдийн холбоо
- МСҮТөв гэх мэт
- Их, дээд сургуулиуд

ЕБСургуулиуд дээр АМЧБО үйл ажиллагааг хэн хариуцдаг нь тодорхой бус, уламжлал болсон хэдхэн үйл ажиллагаа нь зөвхөн хавар 5-р сард зохиогддог зэрэг дутагдал түгээмэл байдаг тул тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөртэйгээр дээрх дутагдлыг арилгах арга технологи ашиглаж ажиллах нь зүйтэй.